



**МОНГОЛ УЛСЫН 2020 ОНЫ ТӨСВИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ
ХУУЛИЙН ТӨСӨЛ ДЭХ УЛСЫН ТӨСВИЙН ХӨРӨНГӨӨР САНХҮҮЖҮҮЛЭХ ХӨРӨНГӨ
ОРУУЛАЛТЫН ТӨСЛҮҮДИЙН ТӨЛӨВЛӨЛТӨД ӨГӨХ САНАЛ**

2020.8.20

2020 оны улсын төсвийн хөрөнгөөр санхүүжүүлэх төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн төлөвлөлтийн чиглэлээр дараах саналыг гаргаж байна. Үүнд:

1. Хөрөнгө оруулалтын төслүүдийг тодорхой байршил, хүчин чадал, хийгдэх ажлыг заахгүйгээр “Улсын хэмжээнд” гэж бөөн дүн оруулсан нийт 24 төсөл, арга хэмжээнд 2020 онд 128.3 тэрбум төгрөгийн санхүүжилт олгохоор төлөвлөснийг төслүүдээр нь тодорхой тусгах (24 төслийн жагсаалтыг Хавсралт 2-оос үзнэ үү).

2020 онд улсын төсвийн санхүүжилтээр хэрэгжүүлэх тодорхой байршил дахь төсөл, нэр заасан байгууллагуудын барилгын их засвар, худалдан авах тоног төхөөрөмж зэргийг хөрөнгө оруулалтын жагсаалтад тусгайлан төлөвлөсөн. Гэвч үүний зэрэгцээ нийт 24 төсөл, арга хэмжээг тодорхой байршил заахгүйгээр “Улсын хэмжээнд” хэрэгжих буюу аль нутаг дэвсгэрт хэрэгжихийг тодорхой заагаагүй нь Төсвийн тухай хуулийн 29.4 дэх “Хөрөнгө оруулалтын төсөвт техник, эдийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг төсвөө батлуулсан, хуульд заасан бусад зөвшөөрөл олгогдсон төсөл, арга хэмжээг тусгана” гэсэн шаардлагыг хангахгүй тул төслүүдийг тодорхой тусгах шаардлагатай байна.

2. Барилга, хот байгуулалтын сайдын багцын XI.4.4 хэсэгт “Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар дараа онуудад хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөв /Улсын хэмжээнд/” гэж 20 тэрбум төгрөгийн төсөвт өртөг төлөвлөн 2020 онд 3 тэрбум төгрөгийн санхүүжилт тусгасныг хөрөнгө оруулалтын төсөл тус бүрээр тодорхой тусгах.

3. Сангийн сайдын багцын VIII.2.1.1 хэсэгт “Гадаадын зээл, тусламжаар хэрэгжих төслүүдийн Монголын талын хөрөнгө оруулалт /Улсын хэмжээнд/” гэж 51.9 тэрбум төгрөгийн санхүүжилт тусгасныг хөрөнгө оруулалтын төсөл тус бүрээр тодорхой тусгах.

4. Хэрэгжих тодорхой байршил заахгүйгээр “Улаанбаатарт” гэж 331 тэрбум төгрөгийн төсөвт өртөг төлөвлөн 2020 онд 6.5 тэрбум төгрөгийн санхүүжилт тусгасан хөрөнгө оруулалтын доорх 4 төслийн зураг төсөв хийгдсэн эсэх талаар тодорхой мэдээлэл оруулах. Эдгээр нь Төсвийн тухай хуулийн 29.4 дэх “Хөрөнгө оруулалтын төсөвт техник, эдийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг төсвөө батлуулсан, хуульд заасан бусад зөвшөөрөл олгогдсон төсөл, арга хэмжээг тусгана” гэсэн шаардлагыг хангахгүй байгаа бол хөрөнгө оруулалтын жагсаалтад зөвхөн зураг төсөв боловсруулах гэдэг томъёоллоор төсөвт өртгийг бууруулж оруулах. Эдгээр төслийн барилгын ажлын гүйцэтгэгчтэй гэрээ байгуулаагүй байгаа бол эдийн засгийн хүндрэлтэй үед Үндэсний урлагийн их театрын барилгыг 152 тэрбум төгрөгөөр, Үндэсний төв цэнгэлдэх хүрээлэнг 80 тэрбум төгрөгөөр санхүүжүүлэх нь зохисгүй юм.

Хуулийн дугаар	Төсөл, арга хэмжээний нэр, хүчин чадал, байршил	Хугацаа		Төсөвт өртөг	2020 онд санхүүжих дүн
		Эхлэх	Дуусах		
II МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД					
II.1.1.29	Үндэсний төв цэнгэлдэх хүрээлэн /Улаанбаатар/	2020	2021	80,000.0	500.0
XI БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН САЙД					
XI.1.96	Улаанбаатар хотын гэр хорооллын дахин төлөвлөлтийн хүрээнд хийгдэх инженерийн шугам сүлжээ /Улаанбаатар/	2020	2021	4,905.4	2,500.0
XII БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ САЙД					
XII.2.1.3	Шинжлэх ухаан, инновацийн төвийн кластер /Улаанбаатар/	2020	2022	94,000.0	3,000.0
XIII СОЁЛЫН САЙД					
XIII.1.1.78	Үндэсний урлагийн их театрын барилга /Улаанбаатар/	2020	2022	152,520.0	500.0
	НИЙТ			331,425.4	6,500.0

5. Хэрэгжих тодорхой байршил, хийгдэх ажлыг заахгүйгээр “салбарын” гэж бөөн дүн оруулсан доорх 2 төсвийн ерөнхийлөн захирагчийн нийт 2 төсөл, арга хэмжээнд 2020 онд 7.7 тэрбум төгрөгийн санхүүжилт олгохоор тусгасныг төслүүдээр нь тодорхой тусгах. Учир нь эдгээр ТЭЗ-ийн багцад санхүүжүүлэх тодорхой байршил дахь төсөл, нэр заасан байгууллагуудын барилгын их засвар, худалдан авах тоног төхөөрөмж зэргийг хөрөнгө оруулалтын жагсаалтад тусгайлан төлөвлөсөн байгаа тул “салбарын” гэж нэмэлт санхүүжилт тусгах нь зохисгүй юм.

Хуулийн дугаар	Төсөл, арга хэмжээний нэр, хүчин чадал, байршил	Хугацаа		Төсөвт өртөг	2020 онд санхүүжих дүн
		Эхлэх	Дуусах		
XI БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН САЙД					
XI.1.58	Барилга, хот байгуулалтын салбарын Улаанбаатар хотод хийгдэх хөрөнгө оруулалт /Улаанбаатар/	2020	2021	25,000.0	5,000.0
XIV ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН САЙД					
XIV.1.1.53	Зам, тээврийн хөгжлийн салбарын Улаанбаатар хотод хийгдэх хөрөнгө оруулалт /Улаанбаатар/	2020	2021	25,000.0	2,691.5
	НИЙТ			50,000.0	7,691.5

6. Барилга, хот байгуулалтын сайдын багцын XI.4.4 хэсэгт “Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар дараа онуудад хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөв /Улсын хэмжээнд/” гэсэн зардалд 2020 онд 3 тэрбум төгрөгийн санхүүжилт төлөвлөснийг төслүүдээр нь тодорхой тусгах.

7. Зураг, төсөвгүй атлаа барилгын ажлын төсөвт өртгийг тусгасан дараах 3 төслийн зөвхөн зураг төсөв боловсруулах төсөвт өртгийг тусгах. Учир нь зураг, төсөвгүй төслийн барилгын ажлын төсөвт өртгийг тусгах нь төлөвлөлтийн шаардлагыг хангахгүй юм.

/сая төгрөг/

Хуулийн дугаар	Төсөл, арга хэмжээний нэр, хүчин чадал, байршил	Хугацаа		Төсөвт өртөг	2020 онд санхүүжих дүн
		Эхлэх	Дуусах		
XIII.1.1.54	Дуурь бүжгийн эрдмийн театрын барилгын зураг төсөв боловсруулах, барилгыг шинэчлэх ажлыг эхлүүлэх /Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг/	2020	2022	54,607.5	500.0
XIII.1.1.76	Төв номын сангийн барилгын зураг төсөв боловсруулах, барилгыг шинэчлэх ажлыг эхлүүлэх /Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг/	2020	2021	52,409.4	500.0
XIII.1.1.77	Улсын драмын эрдмийн театрын барилгын зураг төсөв боловсруулах, барилгыг шинэчлэх ажлыг эхлүүлэх /Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг/	2020	2022	52,025.0	500.0

8. 2020 онд эхлэх төслүүдээс худалдан авах ажиллагаа хийгдээгүй байгаа барилга, байгууламжийн төслүүд ондоо багтах эсэх талаар нягталж үзэх.

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46.1.8-д “Барилга, зам, инженерийн шугам сүлжээ зэрэг тодорхой улиралд гүйцэтгэх онцлог шинж чанартай бараа, ажил, үйлчилгээг худалдан авах ажиллагааг тухайн жилийн төсөв батлагдсан даруйд эхлүүлэх” гэж заасныг хэрэгжүүлээгүй нь нэлээдгүй төслүүд төлөвлөсөн хугацаандаа хэрэгжихгүй байх шалтгааны нэг болж байгаа нь сүүлийн жилүүдийн төсвийн гүйцэтгэлээс харагдаж байна. Хуулийн төслийн танилцуулгын 5.3.7 дахь хэсэгт 2020 оны төсвийн хөрөнгө оруулалтаар шинээр хэрэгжих 916 төсөл, арга хэмжээнээс 253-ийнх нь гэрээг байгуулаагүй байгаа талаар дурджээ. Иймд худалдан авах ажиллагаа хийгдээгүй байгаа барилга, байгууламжийн төслүүдийн санхүүжилтийг эргэн авч үзэх нь төсвийн хөрөнгийг үр ашигтай зарцуулахад ач холбогдолтой юм.

9. Улсын төсвийн хөрөнгөөр санхүүжүүлэх төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн төлөвлөлтийн дэлгэрэнгүй мэдээллийг нийтэд ил болгох. Үүнд:

-2020 онд эхлэх төслүүдийн хувьд зураг, төсөв болон худалдан авах ажиллагаа хийгдсэн эсэхийг төсөл тус бүрээр тусгах

-Тодотголоор нэмэгдсэн төслүүдийн жагсаалт

-Тодотголоор хасагдсан 122 төслийн жагсаалт

-2020 онд санхүүжих дүн өөрчлөгдсөн төслүүдийн жагсаалт.

Хуулийн төслийн танилцуулгын 5.3.7 дахь хэсэгт 2020 оны төсвийн хөрөнгө оруулалтаар 2020 онд шинээр хэрэгжих 916 төсөл, арга хэмжээнээс 663-ынх нь гүйцэтгэгч шалгарч гэрээ байгуулсан, үлдсэн 253 төсөл, арга хэмжээ гэрээ байгуулаагүй ба нийт 122 төсөл хасагдсан талаар дурджээ. Иймд эдгээр төслүүдийн дэлгэрэнгүй мэдээллийг нийтэд ойлгомжтой байдлаар ил болгох нь эдийн засгийн хүндрэлтэй үед төсвийн хөрөнгийг үр ашигтай төлөвлөх, нэн шаардлагатай төслүүдийг санхүүжүүлэх талаар олон нийтийн дунд хэлэлцүүлэг өрнүүлэх ач холбогдолтой юм.

оооооооооооооо



**МОНГОЛ УЛСЫН 2020 ОНЫ ТӨСВИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ
ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛ ДЭХ УЛСЫН ТӨСВИЙН ХӨРӨНГӨӨР САНХҮҮЖҮҮЛЭХ
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨЛТ**

2020 ОНД ЭХЛЭХ "УЛСЫН ХЭМЖЭЭНД" ГЭСЭН ТОДОТГОЛТОЙ ТӨСЛҮҮД

2020.8.20

	Хуулийн дугаар	Төсөл, арга хэмжээний нэр, хүчин чадал, байршил	Хугацаа	2020 онд санхүүжих дүн /сая төгрөг/
			Эхлэх	
IV МОНГОЛ УЛСЫН САЙД, ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА				
1	IV.1.2.8	Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, харьяа байгууллагуудын барилгын их засвар, тохижилт /Улсын хэмжээнд/	2020	2,038.2
VI БАТЛАН ХАМГААЛАХЫН САЙД				
2	VI.2.1	Зэвсэгт хүчний ангиудын барилгын их засвар /Улсын хэмжээнд/	2020	1,050.0
VIII САНГИЙН САЙД				
3	VIII.1.1.3	Гаалийн боомтуудыг шилэн кабельд холбох /Улсын хэмжээнд/	2020	3,000.0
4	VIII.3.2.1	Татварын ерөнхий газрын харьяа байгууллагуудын барилгын их засвар /Улсын хэмжээнд/	2020	700.0
5	VIII.2.1.1	Гадаадын зээл, тусламжаар хэрэгжих төслүүдийн Монголын талын хөрөнгө оруулалт /Улсын хэмжээнд/	2020	51,862.4
6	VIII.3.3.1	Татварын ерөнхий газрын харьяа байгууллагуудын тоног төхөөрөмж /Улсын хэмжээнд/	2020	1,000.0
IX ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН САЙД				
7	IX.4.3.1	Хил хамгаалах байгууллагын авто парк шинэчлэл /Улсын хэмжээнд/	2020	7,150.0
8	IX.5.3.1	Хууль зүйн салбарын тоног төхөөрөмж /Улсын хэмжээнд/	2020	2,400.0
X ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН САЙД				
9	X.3.2.1	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны харьяа байгууллагуудын барилгын их засвар /Улсын хэмжээнд/	2020	400.0
10	X.3.3.1	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны харьяа байгууллагуудын тоног төхөөрөмж /Улсын хэмжээнд/	2020	288.0
XI БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН САЙД				
11	XI.1.78	Орон зайн өгөгдөл, мэдээллийг бүрдүүлэгч байгууллагуудын санг геопорталаар дамжуулан цахимжуулж, хэрэглээнд нэвтрүүлэх /Улсын хэмжээнд/	2020	902.3
12	XI.1.90	Сумын төвийн шинэчлэл хөтөлбөр /Улсын хэмжээнд/	2020	5,000.0
13	XI.1.95	Төрийн өмчийн газрыг зурагжуулж бүртгэн газрын кадастрын мэдээллийн санд оруулж баталгаажуулах /Улсын хэмжээнд/	2020	1,000.0
14	XI.1.110	Хаягийн мэдээллийн нэгдсэн систем /Улсын хэмжээнд/	2020	300.0

15	XI.4.4	Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар дараа онуудад хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөв /Улсын хэмжээнд/	2020	3,000.0
XII БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ САЙД				
16	XII.2.2.4	Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын салбарын их засвар /Улсын хэмжээнд/	2020	11,815.0
XV УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН САЙД				
17	XV.2.1	Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны харьяа байгууллагуудын барилгын их засвар /Улсын хэмжээнд/	2020	105.0
XVI ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ, ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН САЙД				
18	XVI.2.3	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарын харьяа байгууллагуудын барилгын их засвар /Улсын хэмжээнд/	2020	700.0
19	XVI.3.4	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарын харьяа байгууллагуудын тоног төхөөрөмж /Улсын хэмжээнд/	2020	300.0
XVIII ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙД				
20	XVIII.2.6	Эрүүл мэндийн салбарын их засвар /Улсын хэмжээнд/	2020	8,800.0
21	XVIII.3.31	Эрүүл мэндийн салбарын тоног төхөөрөмж /Улсын хэмжээнд/	2020	23,550.0
XX УЛСЫН ЕРӨНХИЙ ПРОКУРОР				
22	XX.2.1	Улсын ерөнхий прокурорын газрын харьяа байгууллагуудын барилгын их засвар /Улсын хэмжээнд/	2020	1,918.8
XXI МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ АУДИТОР				
23	XXI.2.1	Үндэсний аудитын газрын их засвар /Улсын хэмжээнд/	2020	600.0
24	XXI.3.1	Үндэсний аудитын газрын тоног төхөөрөмж /Улсын хэмжээнд/	2020	400.0
		НИЙТ		128,279.7

00000000000000